



“АСБИ” ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 03 сарын 01 өдөр


Дугаар 03

Улаанбаатар хот

Санхүүгийн тайланг батлах тухай

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 03 сарын 01-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “АСБИ” ХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг “Бэст фортуна аудит” ХХК аудитын байгууллагаар баталгаажсан хавсралтын дагуу баталсугай.
2. Батлагдсан санхүүгийн тайланд дурьдагдсан аудитын байгууллагын санамж, зөвлөгөөг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллахыг гүйцэтгэх захирал /Л.Сүмбанд/-д даалгасугай.
3. Санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталгаажуулж, эрх бүхий байгууллагуудад хүргүүлсүгэй.



Д.ХАГВАСҮРЭН



**“АСБИ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2019 оны 03 сарын 01... өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах
комисс томилох тухай

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 03 сарын 01-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бэлтгэл хангах, хурал зохион байгуулах комиссыг дараах бүрэдэхүүнтэйгээр томилсугай.


Комиссын дарга: Л.Сүмбанд

Гишүүд: Б.Должиндэмбэрэл

О.Билгүүн

2. Компанийн тухай хууль, Компанийн дүрэм болон Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмыг мөрдөн ажиллахыг комиссын дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахтай холбоотой зардлыг компанийн үйл ажиллагааны зардлаас гаргахыг гүйцэтгэх захирал /Л.Сүмбанд/-д зөвшөөрсүгэй.



Д.Лхагвасүрэн
Д.ЛХАГВАСҮРЭН



“АСБИ” ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 03 сарын 01 өдөр


Дугаар 01

Улаанбаатар хот


Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйл, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 03 сарын 01-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. АСБИ хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2019 оны 04 сарын 11-ны өдрийн Пүрэв гаригт 10.00 цагт компанийн оффисын байранд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:
 1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох
 2. Компанийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудиторын дүгнэлт, ТУЗ-ийн дүгнэлт
 3. Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн зардлын төсөв
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2019 оны 03 сарын 22-ны өдрөөр тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын товыг 2019 оны 03 сарын 05-ны өдөр, 2019 оны 03 сарын 16-ны өдөр тус тус Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-д заасныг баримтлан олон нийтэд зарласугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн танилцах бичиг баримтын жагсаалтыг 1 дүгээр хавсралтаар, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр зарлах хэвлэлийн эхийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг 2019 оны 03 сарын 08-ны өдөр бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер диллерийн компаниудад цахим хэлбэрээр хүргүүлсүгэй.
7. Хувьцаа эзэмшигчдийн хурлын саналыг хуудасыг 3а, 3б дугаар хавсралтаар баталж, саналын хуудасыг хүлээж авах сүүлчийн өдрийг 2019 оны 04 сарын 10-ны өдрийн 18.00 цагаар тогтоосугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Лхагвасүрэн, тооллогын комиссын даргаар Б.Доржсүрэн, гишүүдээр Ч.Дашцэрэн, Ч.Одонтуяа нарыг тус тус томилсугай.




Д.ЛХАГВАСҮРЭН



2019 оны 03 сарын 01-ний өдрийн
01 тоот тогтоолын хавсралт 1

**“АСБИ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ТАНИЛЦАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

1. Компанийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудиторын дүгнэлт
2. Компанийн бизнес үйл ажиллагааны тайлан
3. ТУЗ-ын хараат болон хараат бус гишүүдэд нэр дэвшигчийн мэдээлэл
4. Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн зардлын төсөв



2019 оны 03 сарын 01-ний өдрийн
01 тоот тогтоолын хавсралт 2

Зар хүргэх мэдээллийн хэрэгсэл:

1. Өдрийн сонин
2. Хувьцаа эзэмшигчдийн утасны дугаар, цахим шуудан

Зар хүргэх өдөр:

2019 оны 03 сарын 05-ны өдөр, 2019 оны 03 сарын 16-ны өдөр

“АСБИ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗАР

“АСБИ” хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2019 оны 04 сарын 11-ны өдрийн Пүрэв гаригт 10.00 цагт компанийн оффисын байранд болох тул Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид та бүхнийг хүрэлцэн ирэхийг урьж байна.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2019 оны 03 сарын 22-ны өдрөөр тасалбар болгоно.

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох
2. Компанийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудиторын дүгнэлт, ТУЗ-ийн дүгнэлт
3. Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн зардлын төсөв

Эрхэм хувьцаа эзэмшигч та бүхэн хурлын материалтай өөрийн харъяалагдах брокер диллерийн компани болон Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс, Ажилчны гудамж 51/1 “АСБИ” ХК-ийн оффист ажлын өдрүүдэд 09.00-18.00 цагийн хооронд хүрэлцэн ирж танилцаж болно.


Дэлгэрэнгүй мэдээллийг О.Билгүүн 99804164 утсаар авч болно.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ


Компанийн нэр:	“АСБИ” ХК
Хаяг:	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс, Ажилчны гудамж 51/1 тоот Компанийн оффисын байр, Утас: 70000198, 99804164
Хурал хуралдах өдөр, цаг:	2019 оны 04 сарын 11-ны өдрийн 10.00 цагт
Хурал хуралдах газар /хаяг, байршил/:	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс, Ажилчны гудамж 51/1 тоот Компанийн оффисын байр, Утас: 70000198, 99804164
Хурлын төрөл:	Ээлжит
Хурал зарлагч:	Төлөөлөн удирдах зөвлөл
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	2019 оны 03 сарын 01 өдөр
Олон нийтэд зарлах огноо:	2019 оны 03 сарын 05 өдөр
Бүртгэлийн өдөр:	2019 оны 03 сарын 22 өдөр
Гэрээний дагуу хурлын баримт бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо:	2019 оны 03 сарын 08 өдөр
Хүргүүлсэн огноо:	2019 оны 03 сарын өдөр
Хурлын даргын нэр:	ТУЗ-ийн дарга Д.Лхагвасүрэн
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр:	Дарга: Б.Доржсүрэн, гишүүд Ч.Дашцэрэн, О.Билгүүн
Баримт бичгийн жагсаалт /хавсралтаар/:	
Баримт бичгийн хуудасны тоо: ширхэг
 хуудас

ХУРАЛ ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛЫН ХАМГААГАХ КОМИССЫН ДАРГА



Д.СҮМБАНД

2019 оны 03 сарын 03 –ны өдөр



2019 оны 03 сарын 01-ний өдрийн
01 тоот тогтоолын хавсралт 3а

**“АСБИ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС**

Санал хураах арга: Энгийн

Хувьцаа эзэмшигчийн овог: _____

Хувьцаа эзэмшигчийн нэр: _____

Регистрийн дугаар: _____

Итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцож байгаа тохиолдолд

Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог, нэр _____

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Брокерийн компанийн нэр: _____

“АСБИ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2019 оны 04 сарын 11-ний өдрийн 10.00 цагт компанийн оффисын байранд болно.

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2018 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, хараат бус аудиторын дүгнэлт, ТУЗ-ийн дүгнэлт			
2	Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн зардлын төсөв			

Хувьцаа эзэмшигч /итгэмжлэгдсэн төлөөлөгч/-ийн гарын үсэг _____ /

Санал авах хуудас үйлдсэн: 2019 оны ____ сарын ____ өдөр


Саналын хуудасыг хүчинтэйд тооцсон эсэх: _____

Тооллогын комиссын дарга _____ /Б.Доржсүрэн/

Саналын хуудасыг хүчингүйд тооцсон шалтгаан: _____

Санамж:

1. Хувьцаа эзэмшигч нь саналын хуудасыг бөглөхдөө санал өгөх хэсэгтээ /+/ тэмдэглэгээ хийнэ. Жишээ нь: Зөвшөөрсөн бол зөвшөөрсөн хүснэгтэд /+/ тэмдэглэгээ хийнэ.
2. Санал авах хуудасны эхний хэсгийг зуучлагч үнэт цаасны компанийн тэмдэг даран баталгаажуулж хувьцаа эзэмшигчдэд өгнө.
3. Засварласан, балласан залруулагатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
4. Хувьцаа эзэмшигчид нь 2019 оны 04 сарын 10-ны дотор хурлын материалтай танилцах бөгөөд өөрийн биеэр оролцох боломжгүй тохиолдолд 2019 оны 04 сарын 10-ны 18.00 цагаас өмнө санал авах хуудсанд саналаа тэмдэглэн үйлчлүүлдэг үнэт цаасны компанидаа хүргүүлнэ.



2019 оны 03 сарын 01-ний өдрийн
01 тоот тогтоолын хавсралт 36

“АСБИ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС

Санал хураах арга: Кумулятив
Хувьцаа эзэмшигчийн овог: _____
Хувьцаа эзэмшигчийн нэр: _____
Регистрийн дугаар: _____
Итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцож байгаа тохиолдолд
Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог, нэр _____
Эзэмшиж буй хувьцааны тоо: _____
Брокерийн компанийн нэр: _____

“АСБИ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2019 оны 04 сарын 11-ний өдрийн 10.00 цагт компанийн оффисын байранд болно.

№	Хэлэлцэх асуудал	ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч	Саналын эрхийн тоо
1	ТУЗ-ийн ердийн гишүүнийг улируулан сонгох	ТУЗ-ийн гишүүн Д.Лхагвасүрэн	
		ТУЗ-ийн гишүүн Л.Сүмбанд	
		ТУЗ-ийн гишүүн Ч.Дашцэрэн	
		ТУЗ-ийн гишүүн Б.Должиндэмбэрэл	
		ТУЗ-ийн гишүүн Б.Доржсүрэн	
2	ТУЗ-ийн хараат бус гишүүнийг улируулан сонгох	ТУЗ-ийн гишүүн Л.Түвшинзаяа	
		ТУЗ-ийн хараат бус гишүүн Э.Буянтогтох	
		ТУЗ-ийн хараат бус гишүүн Ц.Одончимэг	
		ТУЗ-ийн хараат бус гишүүн Л.Нямдаваа	
	Саналын эрхийн тоо		

Кумулятив аргаар санал хураах жишээ:
Тус арга нь санал өгөх эрхийн нийт тоо таны эзэмшиж байгаа саналын эрхтэй энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна. Жишээ нь: Та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг гэвэл ТУЗ нь 9 гишүүнтэй байхад 100 ширхэг энгийн хувьцаа нь 900 саналын эрхтэй /100*9=900/ болох бөгөөд 600 саналын эрхээр ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид санал өгөх, 300 саналын эрхээр ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид санал өгөх эрхтэй болно.

Хувьцаа эзэмшигч /итгэмжлэгдсэн төлөөлөгч/-ийн гарын үсэг _____ / _____ /
Санал авах хуудас үйлдсэн: 2019 оны ____ сарын ____ өдөр

Саналын хуудасыг хүчинтэйд тооцсон эсэх: _____
Тооллогын комиссын дарга _____ /Б.Доржсүрэн/

Саналын хуудасыг хүчингүйд тооцсон шалтгаан: _____

- Санамж:
1. Хувьцаа эзэмшигч нь саналын хуудасыг бөглөхдөө санал өгөх хэсэгтээ +/- тэмдэглэгээ хийнэ. Жишээ нь: Зөвшөөрсөн бол зөвшөөрсөн хүснэгтэд +/- тэмдэглэгээ хийнэ.
 2. Санал авах хуудасны эхний хэсгийг зуучлагч үнэт цаасны компанийн тэмдэг даран баталгаажуулж хувьцаа эзэмшигчдэд өгнө.
 3. Засварласан, балласан залруулагатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
 4. Хувьцаа эзэмшигчид нь 2019 оны 04 сарын 10-ны дотор хурлын материалтай танилцах бөгөөд өөрийн биеэр оролцох боломжгүй тохиолдолд 2019 оны 04 сарын 10-ны 18.00 цагаас өмнө санал авах хуудсанд саналаа тэмдэглэн үйлчлүүлдэг үнэт цаасны компанидаа хүргүүлнэ.